



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/07.

Улаанбаатар хот

Хүчингүй болсон хэвлэмэл хуудас устгах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 2020 оны "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай" хууль, "Засгийн газрын "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлах тухай" 2020 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3.5 дугаар заалт, Засгийн газрын "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх тухай" 2021 оны 226 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.5, 6.19 дүгээр заалт, Газрын дүрмийн 7.1.10, Хэлтсийн дүрмийн 2.7.14 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Монгол Улсын Засгийн газрын 360 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1039 дүгээр захирамжаар тус газрын нэр өөрчлөгдсөн тул 2021 оны ашиглалтаас үлдсэн хэвлэмэл хуудас А4-418, А5-420, Тушаалын А4-110 ширхэг, албан тушаалтны буруутай үйлдлээс үүсэн хүчингүй болсон А4 97 ширхэг нийт 1045 ширхэг хэвлэмэл хуудсыг устгах ажлыг хянаж гүйцэтгэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн (С.Болдоо)-д даалгасугай.

1. Ашиглалтын явцад хүчингүй болгосон 97 ширхэг хэвлэмэл хуудасны нэг бүрийн үнэ 150 төгрөг буюу 14550 (арван дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийг буруутай албан хаагчаас татан авч төвлөрүүлэхийг Бичиг хэргийн ажилтан (Ч.Энхтайван)-д, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Э.Даваахатан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

